

Шударга ёс, эе эвийн сэтгэлгээ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын ёс суртахууны үндэс болох тухай

Нанзаддоржийн Жалбажав, доктор (Ph.D), профессор
Шихихутуг Их Сургуулийн Судалгааны Хүрээлэн
Улаанбаатар, Монгол Улс,
jalbajav@shihihutug.edu.mn; <https://orcid.org/0009-0002-6995-7559>

Article history

Received : 2024-08-31

Accepted : 2024-09-28

Published : 2024-12-20

Түлхүүр үгс

төр ёс, ёс суртахуун, шударга ёс, төрийн үнэт зүйлс, үндэсний аюулгүй байдал, үндэсний эв нэгдэл, эе эвийн сэтгэлгээ, оюуны дархлаа

Keywords

State ethics /statecraft/, morality, justice, state values, national security, national unity, peaceful thinking, intellectual immunity

Хураангуй: Монголчуудын эртнээс нааш уламжлан ирсэн шударга ёс, эе эвийн сэтгэлгээний өв уламжлал нь олон үеийн туршид түүнийг залгамжлагчдын төрийн бодлого, үйл ажиллагааны ёс суртахууны үндэс болоод зогсохгүй монгол төрийн үнэт зүйл болон төлөвшсөн билээ. Утгаа эе эвийн сэтгэлгээний өв уламжлал, эх сурвалж, эе эвээ эрхэмлэх, бэхжүүлэх тухайд Чингис Богдын захиас, сургамжийн зүйлүүд, «Монголчууд эвтэй байхдаа хүчтэй байсан»-ны утга учрыг задлан шинжлэх болно. Үндэсний эв нэгдэл, эе эвийн сэтгэлгээ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын чухал зүйл болох, шударга ёсыг бэхжүүлэх, үндэсний эв нэгдлийг хангах, эе эвийн сэтгэлгээг төлөвшүүлэх бодлого, зорилтын тухай өгүүлнэ.

On justice and accordant being the foundation of the ethics of national security of Mongolia

Jalbajav Nanzaddorj (Ph.D), Prof

Research Institute of the Shikhikhutug University

Ulaanbaatar, Mongolia, jalbajav@shihihutug.edu.mn; <https://orcid.org/0009-0002-6995-7559>

© The Author(s), 2024



Abstract: The heritage of justice and harmony, transmitted by Mongolians since ancient times, has become not only the moral basis of Mongolia's policies and actions for many generations, but also a value of the Mongolian State. It will analyze the significance and strengthening of harmony, the meaning of "the Mongols were strong when they united" with respect to the heritage and sources of the harmony spirit, the message and lessons of Chinggis Bogd and its meaning. The article is about the importance of strengthening the policies and objectives of Mongolia's national security, ensuring national unity and developing peaceful thought.

I. Шударга ёс

Монголын түүхийн эх сурвалж: Монголын нууц товчоо, “Судрын чуулган”, Их Монгол Улсад аялагчид,

элчин төлөөлөгчдийн тэмдэглэл, хаадын захидал зэргээс үзэхэд шударга ёсны ёс суртахуун, эе эвийн сэтгэлгээ нь монгол төрийн бодлогын ноён

нуруу, ёс суртахууных нь үндэс, үеэс үед уламжлагдах үнэт зүйл нь болж иржээ. Их Монгол Улс байгуулагдаж эх дэлхийн хөгжлийн бодлогыг тодорхойлогч их гүрэн болж, 150 гаруй жил өргөжин хүчирхэгжиж байсны нэгэн нууц увидас нь монгол төрийн бодлогын эдгээр үнэт зүйлсийн дотно, гадны түмэн олныг өөртөө татах, эвлэлдүүлэн нэгтгэх их хүчинд байжээ.

“Судрын чуулган”-д дурдсанаар эзэгнэх эрх мэдэл, эд санаатнууд олзлолдон булаалдаж, алалдан арцалдаж, Хамаг Монголын төрийг бусниулж, халуун гал голомтыг сандаан хөх монголыг хөлдөө чирсний уршгаар “ам бүлийн эе эвдэрч, эр нөхөр, эхнэр эмсийн хооронд хэрүүл тэмцэл үл тасрах болж, ахас ихсийг үл хүндэлж, эцэг эхийн сургаалыг үр хүүхэд нь үл дагаж, ахан дүүс, анд нөхдүүд өширхөн дайсагналцаж” харийн халдлага, хар санаатны өмнө хүчин мөхөстөн доройтож, орших эс оршихуйн хувь заяаг дэнсэлсэн цаг үүхийн зайлшгүй шаардлагаа улс үндэстнээ нэгтгэж, авран амаржуулах нь нийгмийн бодит хэрэгцээ байжээ (Рашид ад-Дин., Судрын чуулган. II боть 2002). Энэ түүхэн захиалгыг Чингис хаан мөнх тэнгэрээс заяагдсан “хувь тавилан”, авьяас билэг, шударга ёс, эе эвийг хичээх ёс суртахууны их хүч, манлайллаараа гүйцэлдүүлжээ.

Тэмүжин, олхонуудын оюут сэцэн Өүлэн эхийн сургаал, хатуужил тэмцлийн хатан тэвчээр, ялах ялагдахын зовлон жаргал, арга ухаан, зорьсондоо хүрэх шаргуу хичээл зүтгэл, дайчин зориг, удам угсаагаа удирдан манлайлах үүрэг хариуцлага, ухаан санааг хаад боржигон удмаасаа өвлөсөн, хар багаасаа өнчрөл хагацал,

өлөн зэлмүүн амьдрал, өшөөтний заналхийлэл, доромжлол, басамжлал, бялдуучлагчийн өв мэхийн уршиг хорыг биеэр туулж, хэрсүүжин ухаажсан тэр цаг үеэсээ л шударга ёсны ач тусыг бусдаас илүү ухаарч өөрийн нэгэн насны эрхэм зорилгоо болгожээ. Иймээс Чингис хаан шударга ёсыг ямагт тэргүүн зэрэгт тавьсаар иржээ.

Ерөөс шударга ёс бол Монголчуудын сэтгэлийн гүнд агуулагдаж амьдрах аж төрөхийн нэг чиг баримжаа нь болж байдаг чанар ажээ. Чингис хаан ёс суртахууны энэ эрхэм чанарыг өөртөө шингээн төрийн бодлого үйл ажиллагааны хөдөлшгүй зарчим болгон мөрдүүлжээ.

Жувейни: “Тэдний монголчуудын шударга хичээнгүй байдлыг хэлбэл гайхалтай хэмжээнд хүрчээ. Арван түмэн цэргийг ерөнхийлөн захирдаг жанжин байлаа ч хамаагүй, хэрэв алдаа, осол гаргасан байвал хаанаасаа хэдий хол алслагдсан ч байг, хаан нь морьт хуягаасаа ганцханыг илгээвэл даруй тогтсон арга хэлбэрээр өнөөхийг нь шийтгэж чадна. Жишээлбэл, толгойг нь авна гэсэн бол толгойг нь огтолно. Алтыг нь авна гэсэн бол биенээс нь алтыг авч одно” гэх зэргээр бичжээ (Жувейни М. 2006, 113).

Шударга ёсыг монгол гэрийн тоонотой адилтгаж болно. Тооногүй монгол гэр байдаггүйтэй нэгэн адил аливаа хүнд авьяас мэдлэг байгаад ч шулуун шударга, ариун явдалгүй бол хүний мөс чанараа алдана. Шударга ёс алдагдвал улс орон ч өөдлөн дэвжихгүй. Чингис хаан шударга удирдлага бүхий засаг төрийг цогцлоосон (Нарангэрэл С. 2020). Энэ тухайд Чингис хаан хутагт арш Чан чунь бомбод илгээсэн захидалдаа улс орондоо «чин сэтгэлээр чигч шударгыг эрхэмлэн тогтоогоод,

сүйтгэн бүрэлгэхийг хориглон зогсоож, өмсөх хувцас, идэх хоолоон адуучин, үхэрчинтэй хуваалцан, ард иргэдийг үр хүүхэдтэйгээн адил үзэж, цэрэг дайчид, эрдэмтэн мэргэдийг ах дүүгээн мэт хүндэлж, эв эеийг эрхэмлэн, энэрэл хигийг түгээмүй» гэжээ (Ли Жичан. 2010).

Чингис хааны үед хахуулиар, шударга бус үйлээр албан тушаал, эрх мэдэл, гавьяа шагналд хүрч байсангүй. Байгуулсан гавьяа, шударга хичээл зүтгэл, эрдэм ухаан, ёс суртахууны чанараар нь хүнийг албан тушаалд томилж, шагнан урамшуулж байжээ. Германы эрдэмтэн Удо Б.Баркман «Сонирхолтой нь Чингис хааны цусан төрлийнхөн удирдах албан тушаал бараг хашиж байсангүй. Тэгэхлээр орчин үеийн боловсон хүчний бодлогод ч Чингис хаанаас суралцууштай» (Удо Баркман. 2012, 423) гэх зэргээр бичжээ. Английн түүхч, зохиолч, аялагч Жон Мэн «...Тэрбээр өөрийн байлдан дагуулалтаасаа хэмжээлигүй их ашиг олох боломжтой байсан хэдий ч, энэ боломжоо ямар ч л байсан хувийнхаа зорилгод ашиглаагүй байдаг юм. Чингис хаан авлига, хээл хахуульд өртөөгүй, харин нээлттэй, өгөөмөр хүн байсан бөгөөд тэрээр зоригжуулан зохион байгуулагч, юм юмыг сонирхон мэдэхийг хүсэгч итгүүлэгч гээд олон олон сайн чанарын эзэн» байжээ (Жон Мэн. 2012, 31).

Марко Поло «Чингис бол баатар зоригтой, билиг ухаантай, хавтай идэрхэг хүн ажээ... Чингис хааны засаглал төв шулуун, хаан нь нигүүлсэнгүй өгөөмрийг мэдээд, олон ард дуртайяа дагасан ажгуу. Чингис хаан газар бүрд дураараа хэрэн нутаглаж байсан үй олон иргэнийг хураан захираад, газар нутгаа улам

өргөтгөх дайн хийхээр шийджээ» гэсэн гярхай дүгнэлтийг номондоо хийжээ. Жак Уэтерфорд Чингисийн төрийн шударга ёсны тухай: Ихэнх захирагч өөрсдийгөө хуулиас дээгүүр тавьдаг бол Чингис хаан ихэс дээдэс, дорд малчныг ч хуулийн өмнө адил тэгш хариуцлага хүлээхийг шаарддаг байлаа. Ямар ч шашинтан байсан шударга ёсыг нийтээр дагаж мөрдөхийг харьяат албатдаа шаарддаг, тэр эзэмшил нутгаа шүтэн бишрэх эрх чөлөөг бүрэн хангасан юм. Тэр ихэс дээдсийн хэргэм зэрэг, эрх ямба, угсаа гарвал гэх мэт феодалын тогтолцоог халж, хувь хүний гавьяа зүтгэл, үнэнч шударга байдал, ололт амжилтад тулгуурладаг шинэ тогтолцоог бий болгосон юм гэжээ (Жэк Уэтерфорд. 2012, 102).

Чингис хааны төрийг үзэх үзэл, түүний ёс суртахууны чөмөг нь болсон шударга ёсны үзэл баримтлал түүний залгамжлагчид, үр ач нарын үед уламжлагдан хөгжиж байсныг түүхийн сурвалжууд нотолдог байна. Их хаад “Их хаан хүмүүн заавал шударга, өгөөмөр, эе эвийг хичээдэг, тулгатай болж өгвөл тийм байх ёстой гэсэн итгэл, үнэмшилтэй байжээ. Ч.Жүгдэр абугай Өгөдэй их хаан эцгийн сургаалыг хэлбэрэлтгүй дагаж шударга ёс, эрдэм боловсролтой бичиг номын хүмүүсийг эрхэмлэх бодлого барьж байсныг онцолсон нь бий. Нэгэн баримт: «Алтан улсыг эзлэн авахад засгийн хэргийг ерөнхийлөн шийтгэх яам байгуулаад ерөнхий сайдаар нь нөлөө бүхий бичгийн хүн Елюй Чу-цайг томилон түүнийг үнэлж Өгөдэй хаан хэлэхдээ: Чи бол өдөр, шөнөгүй миний улс төрийн тул бодож явдаг мэргэн бат сайд мөн. Бусад ажил эрхтэй сайд түшмэдийн дүргүй хүрэх болов

уу гэж бодохгүй ил шууд хэлдэг бөгөөд би ч өөрөө дур зоргоор хэд хэдэн удаа засаг хуулийг зөрчихөд эрхбиш ирж хориглох нь эзнийг үл хориглоно хэлбүүл хэрэглэх чин үнэн нь илрэв. Энд тэнд болж буй, болохгүй зохисгүй зүйлүүдийг ил шууд хэлж цөм өөрийн муу болохоос үл зайлан улс төрийн тул бодсон шударга газар болой» хэмээн түүний үйл ажиллагааг өндөр үнэлж байжээ (Жүгдэр Ч. 1984, 41).

Хубилай хаан (1215-1294) тэр цагийн эрдэм боловсролыг сайтар эзэмшин төрийн хэрэгт шударга ёс, эрдэм соёл, улсын засаг заслал, хууль дүрэм, ёс журмыг шинэчлэн тогтоосноороо түүхэнд Хубилай сэцэн хаан хэмээн мөнхөрчээ.

Хубилай сэцэн хааны Монгол төрийн бодлогын ёс суртахууны үндэс, зарчим болгон хөгжүүлсэн “Хоёр ёсны номлол”-д туссан хүн өөртөө байгаа уур, мунхаг, тачаангуй хэмээх гурван хорыг дарах тухай, өршөөлгүй хааныг гэвчих, шуналтай ноёдыг гэвчих, муу хүнийг ихэд эс дарах, сайн хүнийг ихэд эс магтах, лам хүний эдэд үл горилох, хаан ихэстэй эс эсэргэлдэх, хааны санг эс хомстгох, багш хүний эдийг эс булаах зэргээр журамлагдсан зүйлүүд (Бира Ш. 2006) нь чухамдаа шударга ёсны үндсэн шаардлагуудыг хуульчилсан хэрэг байжээ.

Гүюгийг их хаан сууринд залахдаа алтан ургийнхан түүнд хандан *«дээшээ бурхныг хар, доошоо сууж байгаа эсгийгээ хар. Хэрэв чи улсаа сайнаар удирдаж өгөөмөр шударга байх юм бол бүгд чамайг хүндэтгэн, чиний алдар суу түгжэ, бүх дэлхий чиний өмнө сөгдөн, чиний юу хүссэн бүхнийг бурхан чамд илгээнэ. Хэрэв чи муу үйл хийвэл золгүй зовлонт амьтан болж, сууж буй эсгий чинь чамд үлдэхгүй*

болно» (Плано Карпини. 1998, 22) гэж захисан гэдэг.

Чингис хааны залгамжлагчдын үед түгэн тархсан “Субаашид” хэмээх билиг сургаалд:

“Агуу ухаан болоод шударга төвшин ноёд Алтан иргэн ба төрийн хэргийг олон шигтгэюү Адилтгавал сайн сумаар мэргэн харваач харвбал Аль зорьсноо алдалгүй онох мэт” гэжээ.

Шударга ёс нь монгол төрийн түүхэнд үеэс үед уламжлагдан монгол хүний зүрх сэтгэлд багтай суусан бөгөөд төрийн хэргийг түмний тусын тулд тэгш шулуун хөглөн явуулах, төрийн өөрийнх нь хүч чадал, нэр хүнд, нөлөөнийх нь үндэс суурь болсон эрхэм үнэт зүйл юм.

II. Эе эвийн сэтгэлгээ

“Монголчууд эвтэй байхдаа хүчтэй байдаг” гэсэн эе эвээ хичээх сэтгэлгээ нь “МНТ”, “Эрдний эрхи”, “Алтан товч”, “Судрын чуулган” зэрэг судар бичгүүд, түүх шастир, үлгэр домог Чингис хаан, их хаадын сургаал, бичиг захидлуудад дархлагдаж үеэс үед уламжлагдан иржээ.

Алангуа эхийн домгоос аваад “Арга хүчээ их болгоё гэвэл ард цэрэг юугаан асар, уужим сул тараая гэвэл эе эв юугаан ямагт хичээ”, Бие хэврэг, билиг мөнх. Улсын эзэн сайд хэн ч бай олондоо хүндлэгдсэн эрдэмтэн мэргэд ухаантныг гүнээ хүндэтгэх хэрэгтэй “Бие бөх болбоос ганцыг яльюу, эе эв бөх болбоос олныг яльюу” гэсэн Чингис богдын сургаал хэзээ ч үл хуучрах оюуны их өв бөгөөд хүмүүний хооронд, улс оронд эе эвийг эрхэмлэх

нь өрх гэр, улс орон энх амгалан, хүчирхэг, аюулгүй оршихын нэгэн баталгаа болохыг нотолж байдаг.

Ата Малик Жувейны “Дэлхийг байлдан дагуулагчдын түүх” шастиртаа “Хөвгүүд, дүү нартаа ямагт эв найртай байж, бие биедээ тус дэм өгч, эе эвээ бэхжүүлэхийг чармайх хэрэгтэй гэж үргэлж захин сургах, явал эвтэй байх ... тухай үлгэр жишээг таниулдаг байсныг тэмдэглэж үлдээжээ.

*Хоёр хүн эвтэй болбоос
Төмөр хүрээ мэт бэх
Хорин хүн эвгүй болбоос
Эвдэрхий хүрээ мэт хэврэг
Өнөр хүн эвгүй болбоос
Өнчин хүний элэг болох
Олон хүн эвгүй болбоос*

*Оорцог (нөхөргүй, зожиг хүн, ред.)
хүний идэш болох”* (Жувейни М. 2006) хэмээсэн нь Чингис хааны эе эвийн үзэл баримтлал нь юм.

Плано Карпини “Тэд хоорондоо маргаж, хэрэлдэнэ гэж бараг үгүй, зодолдох, өөр зуураа дайтах, муудалцах бие биенээ алж шархдуулах явдал огт байхгүй” (Плано Карпини. 1998, 22) гэжээ. Гэхдээ Академич С.Нарангэрэл «*Чингис хааны ёс суртахуун – эрх зүйн шастир*”-таа эрх мэдэл булаалдах албан тушаал хөөцөлдөх, хахуульд идэгдэх, хов жив, гүжир гүтгэлэг, хувийн ашиг хонжоог урьтал болгох явдал эв эийн суурийг ганхуулж, түүхийг эвдэн нураадаг болохыг монголчуудын үе үеийн түүх баталсан юм» (Нарангэрэл С. 2020) гэдгийг онцлон тэмдэглэжээ. Рашид-ад-дины “Судрын чуулган”-д Жочи (Зүчи), Цагадай хоёрын зөрчил Хорезмын дайнд ямар уршиг тарьсныг сургамжлан бичсэн нь бий (Рашид ад-Дин., Судрын чуулган. Нэгдүгээр дэвтэр 1994, 121).

Монголын түүхэнд Хубилай, Аригбухын тэмцэл, их хаад (Өгөдэй, Цагадайн удмынхан хийгээд Гүег нарын зөрчил, хожим феодалын бутрал гээд монголын хүч чадлыг сулруулж улмаар бусдын (Манжийн) эрхшээлд ороход хүргэж байсан гашуун туршлага, сургамж бишгүйдээ бий.

Чингис хаанаас хойш хөвгүүн Өгөдэй, ач Бат, Мөнх, Хубилай, Хүлэгү зэрэг хаад эе эвийг хичээж улс гүрнээ хүчирхэгжүүлж ялалт батлуулж байсан түүх ч бий. “Субашид” билиг сургаалд:

*“Эе эвээ нэгтгэн олноор хамжвал
Эгэл дорд улс ч байв их үйлсийг
бүтээюү*

*Эрт цагт нэгэн арслангийн
зулзагыг олон шоргоолж*

*Энд тэндээс нь зэрэгцэн хазсаар
алсан үлгэр мэт гэсэн байдаг.*

*Мөнх тэнгэрийн хүчний үзэл санаа,
шударга ёс, эе эвийн сэтгэлгээ*

нь Их Монгол Улсын мандан бадрал, ялалтын нэгэн ундарга болж байжээ.

Монголчуудын эе эвээ хичээх сэтгэлгээ “Монголын нууц товчоо”, “Эрдэнийн эрхи”, “Алтан товч” зэрэг судар бичгүүд, үлгэр домог, “Тэсэр”, “Жангар” туульсдаа сүсэглэн дээдэлж, хойч үеийнхээ ой тойнд, үндэснийхээ ой санамжид дархлан хадгалж иржээ.

Энэтхэгийн Дж.Неру, Их Британийн У.Черчилл, АНУ-ын Фр.Рузвельт, Хятадын Дэн Сяо Пин нарын олон үндэстний улс гүрний их удирдагч нар болон ертөнцийн мэргэд ч шударга ёс бол нийгмийг ариутгагч, үндэсний эв нэгдлийг бэхлэгч, ялалт амжилтын нэгэн эх сурвалж болохыг сургасан нь цөөнгүй. Тухайлбал, Фр.Рузвельт АНУ ХХ зууны 20-30-аад оны их хямралыг улам хүчирхэгжин

сэргэн мандаж туулсны гол учир нь америкчууд хүн төрөлхтний ардчилал, эрх чөлөөний манлай орны иргэд гэдгээ ухаарч эв нэгдэлтэй байсны үр ач гэжээ .

Монгол Улс хэдийгээр нэг үндэстэн (халх, хүн амын 80 хувь нь) давамгайлсан, төрийн унитар буюу нэгдмэл тогтолцоотой боловч халх, хасаг, буриад, дөрвөд, баяд, чантуу, торгууд зэрэг 10 гаруй үндэстэн ястны өлгий орон.

Монголын төр 2200 гаруй жилийнхээ түүхэнд үндэстэн, ястнаа их бага гэж ялгаварлалгүйгээр хэл соёл, зан заншлыг хүндэтгэн эрх тэгш, эв нэгдэлтэй аж төрөх бодлого баримталж иржээ. Үүний үрээр Монголын соёл, иргэншил олон ястан, угсаатны соёлын бат цулыг бүрдүүлэн хөгжиж буй билээ.

Эдүгээ Монголд ардчилал түгэн, хувийн өмчид суурилсан зэх зээлийн харилцаа төлөвшин, үндэсний ухамсар, соёл хөгжих таатай нөхцөл бүрдэн байна. Үүний сацуу зах зээлийн чөлөөт өрсөлдөөн, хувийн өмчийн өсөлт хөгжил нь нийгмийн социал ялгарал, баян чинээлэг байдал, ядуурлын зөрүүг ихэсгэн нийгмийн өөр өөр ашиг сонирхол бүхий бүлэг давхаргууд төлөвших үндэс болж байна. Эрдэмтэн судлаачдын судалгаанаас үзэхэд эдүгээ Монгол Улсад баячууд, хүн амын чинээлэг хэсэг буюу дундчууд, ядуучууд, нэн ядуу хэсэг буюу үгээгүйчүүд (өмч хөрөнгөгүй, тогтмол орлогогүй, олдсоноор амь зуудаг, зарим нь орон гэргүй) гэсэн социал давхраажилтын ерөнхий дүр зураг ажиглагдаж байна. Социал ялгарал, олон ургалч үзэл бодол, ашиг сонирхлын зөрүү зэргийг зарим эрдэмтэн судлаачид “төвөөс

зугтах” хүчин, задралын далд совин гэх зэргээр нэрлэж байна.

Чөлөөт өрсөлдөөн, бизнесийн эрх чөлөө нь улс орон хэмээх нэгэн эвсэг өнөр бүлийг бүрдүүлж буй үндэстэн, ястны эдийн засгийн харьцангуй бие даасан байдлыг бэхжүүлэхийн сацуугаар үндсэрхэх, нутгархах, явцуурах үзлийг нь өдөөн сэргээх хүчин зүйл ч болдог байна. Хэрвээ төрийн эдийн засаг, нийгмийн бодлогод нийгмийн бүлэг, давхарга, үндэстэн, ястны хувьд нийгмийн материал баялгийн хуваарилалт, хөрөнгө оруулалт, татварын бодлого зэрэгт шударга ёсны зарчим алдагдах, хүн амын дунд үндэс угсаа, шашин шүтлэг, хэл соёлын өчүүхэн төдий ч ялгаварлах хандлага гарах, газар авбал урьдчилан тооцоолох аргагүй уршиг тарих, салан тусгаарлах, санаа бодол, үйл ажиллагаа үржин төлжих хөрс нь болдгийг Испани (Барселона), Их Британи (Шотланд, Умард Ирланд), Хятад (Шинжаан, Уйгар), Украин (Донбасс), Ойрх Дорнодод өрнөн буй үндэсний асуудал, зөрчил тэмцэл харуулж байна.

Монгол Улсад үндсэрхэх, нутгархах үзэл бодол цухалзсаар буйг нуух юмгүй мэт. Унасан газар, угаасан ус, яс үндэс, угсаа гурвалаараа бахархах нь эрүүл ухаантай хүн бүрт заяагдсан мэдрэмж ухаарал. Гэхдээ энэ нь голдирлоосоо хальж бүлэгэрхэн явцуурах, бүтээн байгуулалтын бодлого тодорхойлох, боловсон хүчнийг шилж сонгох зэрэг төрийн бодлогын зүйлд нөлөөлөх, түүхийг мушгин гуйвуулах зэрэг зиндаанд хүрвэл уршигийг нь тааварлах аргагүй. Бөхөө барилдуулахдаа хүртэл ихэд нутгархан талцах болсон нь өөгшүүлэх зүйл огт биш. Ерөөс онцгойрох, ялгарах зүйлээрээ түрүү

барих нь орон гэрээ бусниулах нигууртайг эцэг дээдэс маань сургаж, сургамжилсан байдаг нь цөөнгүй.

Нэгэн зүйлийг онцлон тэмдэглэхэд гадаадын болон дотоодын зарим судлаачид (Урадын Э.Булаг, Бат-Отгон зэрэг) Монгол Улсад үндэсний эв нэгдлийн зорилгод хор хөнөөл учруулж мэдэх угсаатны улс төрийн хямрал (ethnico-political crisis) бий болсон (Урадын Э.Булаг. 2020, 52, 58-59) бөгөөд угсаатан, үндэстний ангиллын төөрөгдөл их байгаа зэрэг нь улс үндэсний эв нэгдэл, аюулгүй байдалд уршиг тарьж мэдэх зүйл гэснийг огт анзаарахгүй байхын аргагүй.

Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал зэрэгт үндэсний, үндэстний, угсаатан, ястан, үндэстний олонх, цөөнх зэрэг ойлголтыг өөр өөрөөр тодорхойлсон, Үндэсний статистикийн тайлан, мэдээ, хүн амын тооллогын үр дүн, хүн амын бүртгэл судалгаа, мөн Монгол Улсын Элчин сайдын яамдын зүгээс гадаад орнуудад түгээж буй сурталчилгааны материалуудад дээрх ангилал, ойлголтын ихээхэн зөрүүтэй байгаа, мөн тэдгээрийн англи, орос, герман, хятад, испани зэрэг гадаад хэлэн дээр орчуулга бүр ч ойлгомжтой бус зэрэг нь улс төрийн бүр ч ноцтой алдаа, уршиг, үр дагаварт хүргэх нигууртайд дүгнэлт хийн холбогдох судалгаа дүгнэлт хийх, эмхлэх, цэгцлэх хэрэгтэй болсныг онцлон тэмдэглэж байна.

Күнзийн номлолд *«Нэрийг зөв хэрэглэхгүй бол хэл яриа зөв биш болно. Хэл яриа зөв биш бол үйл хэрэг амжилт эс олно. Үйл хэрэг амжилт эс олбол ёслол, хөгжим бадрангуй биш болно. Ёслол, хөгжим бадрангуй биш бол ял шийтгэл шударгаар оногдохгүй.*

Ял шийтгэл шударгаар оногдохгүй бол эгэл ард түмэн хаана толгой, хөлөө тавихаа (хэрхэн амьдрахаа) эс мэднэ. Иймээс төрийн хүн аливаа зүйлийг нэрлэсэн нөхцөлд уг нэршил хэл ярианд тусгагдаж үйлдэл болдог. Төрийн хүн уг хэлэхдээ дур зоргоороо авирласан байж болохгүй ээ» (Confucious 2007, 88-89)(хэлээр).

Нийгмийн оюун санаанд ч зарчмын гэмээр өөрчлөлтүүд гарлаа. Иргэдийн ертөнцийг үзэхүй, амьдрах хэв маяг, үнэт зүйлсийн чиг баримжаа үндсээрээ өөрчлөгдөн улс төрийн олон ургальч үзэл дэлгэрч олон төрөл шашин шүтлэг чөлөөтэй нэвтэрч, нутагшин байна. Ганцхан жишээ дурдахад Монгол Улсад бүртгэлтэй, бүртгэлгүй христийн, лалын болон бусад шашин, сүм хийд, мөргөл шүтлэгийн байгууллага, газрын тоо хэдэн зууд хүрч тэдгээрийн шүтэн бишрэгчдийн тоо 100 мянгаас хол давжээ.

Ертөнцийг үзэхүйн өөр үзэл бодол, итгэл үнэмшлийг үл тэвчигч (ийм шинж байдал загалмайтны, лалын болон бусад олонх шашинд байдаг) олон шашин дэлгэрсэн улс орныг торхтой дарин дээр сандаалагч нэгэнтэй зүйрлэсэн нь бий. Шинэ нөхцөл байдалд төр, шашны харилцааг үндэсний аюулгүй байдал, үндэснийхээ соёл, иргэншлийг хангах, хамгаалах болон иргэнийхээ улс төрийн, шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хангах бодлогын зангилаан дээр хууль зүйн ухаалаг, оновчтой зохицуулалт хийх, түүний дотор монголчуудын соёлын их уламжлал, сан хөмрөгийг өөртөө агуулсан эцэг өвгөд, ахмадуудаас аваад монголчуудын олонхын оюун санаа, яс маханд нь шингээстэй уламжлалт шашныхаа статусыг оновчтой тодорхойлох нь

төрийн бодлогын тулгар асуудал гэж үзэж байна.

Энэ цаг үед үндэсний эв нэгдэлд хамгаас илүүтэй уршиг тарих үзэгдэл бол нийтээрээ, дээр доргүй, хот хөдөөгүй улс төржин талцах эмгэг юм. Улс төржилт ардчилсан, олон ургальч үзэл дэлгэрсэн, олон намын тогтолцоотой улс оронд байдаг л үзэгдэл бөгөөд улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хангах, тогтвортой хөгжилд хүрэх, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах, дарангуйлал, хэсэг бүлгийн ноёрхол, дур зоргын эсрэг нэн чухал хүчин зүйл болох учиртай ажээ.

Гэтэл Монгол Улсад улс төржилт энэхүү утга чанар, хэм хэмжээгээ алдаж, олигарх бүлэглэлүүдийн явцуу эрх ашгийн төлөө тэмцэл болох магадлал их байгаа нь түүнийг нийгмийн нэн хор уршигтай үзэгдэл болгож байна. Энэ эмгэг нийгмийн амьдралын бүх хүрээ, нийгмийн бүх бүлэг, давхарга тэр бүү хэл нийгмийн үндэс болсон гэр бүлд хүртэл нэвчин халдварлаж, нийгмийн тогтвортой байдал, төрийн удирдлагын нэгдмэл байдал, үндэсний эв нэгдэлд ан цав суулгаад зогсохгүй нийгмийн материал баялгийн хуваарилалт, бүтээн байгуулалт, хөгжлийн бодлогод хүртэл нөлөөлж уршиг тарьж буйг нуух юмгүй.

Ийм нөхцөлд судлаачийн хувьд дараах зүйлсийг санал болгож байна.

Ашигласан материал

- Рашид ад-Дин. 2002. *Судрын чуулган. Нэгдүгээр дэвтэр*. орч. Сүрэнхорлоо Ц. Улаанбаатар.
- Жувейни М. 2006. *Дэлхийг байлдан дагуулагчдын түүх*. орч. Бадамням М. Улаанбаатар: “Адмон” ХХК.

Нийгэмд шударга ёс тогтоох, эе эвийн сэтгэлгээг бэхжүүлэх бодлого, үйл ажиллагааны үндсэн чиглэлийн талаар:

- o Төр, иргэний нийгэм, эрдэмтэн судлаачдын хамтын оюун ухаанаар улс үндэстний, ард түмний нийтлэг, язгуур эрх ашиг, эрхэмлэн сахих, хадгалан хамгаалах үнэт зүйлс (нийт улс үндэстний, өрх гэр бүлийн, иргэний г.м.)-ийг шинжлэх ухаанчаар тодорхойлж, баталгаажуулан хэрэгжүүлэх тогтолцоог төлөвшүүлэх;
- o Үндэсний аюулгүй байдал, эв нэгдлийн оюун санааны дархлаа нь болсон эх оронч үндэсний үзэл хүмүүжил, үндэсний бахархал, ой санамжийг бэхжүүлэх;
- o Нийгмийн баялгийн хуваарилалтад шударга ёсыг тогтоон хэлбэрэлтгүй мөрдөх;
- o Нийгмийн дундаж давхаргыг өргөжүүлэх, бэхжүүлэх;
- o Төр, нийгмийн удирдлагын бүх институт (субъектууд)-эд иргэнийг угсаа гарвал, яс үндэс, үзэл бодлоор ялгаварлан гадуурхах, нийгэмд талцал, зөрчилд хүргэж буй улс төржилтийг саармагжуулах, явцуурхан бүлгэрэх аливаа үзэл, оролдлоготой шийдвэртэй тэмцэх тогтолцоо, механизм (арга хэрэгсэл)-ыг төлөвшүүлэх;
- o Угсаатан, ястны эрхийн тэгш байдлыг бодитой хангах.

Нарангэрэл С. 2020. *Чингис хааны ёс суртахуун ба эрх зүйн шастир*. Улаанбаатар: “Жиком принт” ХХК.

Ли Жичан. 2010. *Чанчунь бомбын Өрнө этгээдэд зорчсон тэмдэглэл*. Ганбаатар Я.

- орч. Ганбаатар Ц. Улаанбаатар.
- Удо Баркман. 2012. *Чингис хааны үед төр цэргийн элит давхарга болж хөгжсөн нь.*//Монголын түүх, улс төрийн тухай өгүүллүүд. Улаанбаатар.
- Жон Мэн. 2012. *Чингис хааны манлайллын нууц.* орч. Дашзэвэг Ц. Улаанбаатар:
- Жэк Уэтерфорд. 2012. *Өнөөгийн ертөнцийг үндэслэгч эзэн Чингис хаан.* Улаанбаатар:
- Жүгдэр Ч. 1984. *Чингисийн төрийн үзэл, цэргийн урлаг.* Улаанбаатар: ФСЭХ., ШУА, ШУА-ийн хэвлэх үйлдвэр.
- Бира Ш. 2006. *Их Монгол Улсын түүх, үзэл суртлын зарим онцлог асуудлууд.* Улаанбаатар:
- Плано Карпини. 1998. *Монголчуудын түүх.* орч. Нямаа Л. Улаанбаатар:
- Рашид ад-Дин. 1994. *Судрын чуулган. Нэгдүгээр дэвтэр.* орч. Сүрэнхорлоо Ц. Улаанбаатар:
- Урадын Э.Булаг. 2020. *Монгол дахь ястны үзэл ба үндэсний эв нэгдэл, тэдгээрт холбогдох эрх зүйн асуудал.* Улаанбаатар:
- Confucius, The Analects of Confucius. 2007. *Күнзийн сургаал.* Translated by Burton Watson. New York: Columbia University Press.